

ТӨСӨЛ

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИХ, АРЧЛАХ, ЗАСВАРЛАХ, ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТ ТАВИХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргасан, Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагад өмчийн хэлбэрийг үл харгалzan тухайн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмын хавсралтад заасан суурь нөхцөл шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох ажлын төрлөөр тусгай зөвшөөрөл олгоно.

1.3. “Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ тусгай зөвшөөрөл”-ийг /цаашид тусгай зөвшөөрөл гэх/ ажлын хэсгийн гаргасан дүгнэлтийг үндэслэн авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгоно.

ХОЁР. Тусгай зөвшөөрөл олгоход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, эрх олгох нөхцөл

2.1. Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулахыг хүссэн аж ахуй нэгжийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бааз, техникийн хангамж, инженер техникийн мэргэжлийн ажилчид болон бусад шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж дүгнэлт гаргах ажлын хэсгийг Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар байгуулна.

2.2. Тусгай зөвшөөрөлтэй холбогдсон мэдээллийн сан бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах, гэрээний биелэлтэнд хяналт тавих, тайлан мэдээнд дүн шинжилгээ хийж, дүнг тайлагнах ажлыг Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

2.3. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн аж ахуйн нэгж нь “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан бичиг баримтыг бүрдүүлнэ.

2.4. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн аж ахуйн нэгж нь тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ. Үүнд:

- 2.4.1. Хүсэлт гаргагчийн мэдээлэл
- 2.4.2. Холбогдох ажлын төрлийг хүссэн өргөдөл
- 2.4.3. Удирдах ажилтнуудын мэдээлэл
- 2.4.4. Инженер техникийн ажилтны мэдээлэл

2.4.5. Механизм тоног төхөөрөмжийн жагсаалт мэдээлэл
Ажлын хэсэг өргөдлийг хүлээж авснаас хойш дүгнэлт гаргах явцад шаардлагатай бусад баримт бичгийг шаардаж болно.

2.5. Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулахыг хүсэгч аж ахуйн нэгж нь энэ журмын хавсралтад заасан суурь, нөхцөл шаардлагыг хангасан байна.

2.6. Тусгай зөвшөөрөл авахыг хүссэн аж ахуйн нэгж, байгууллагаас энэ журмын 2.3, 2.4, 2.5-т заасан баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” Монгол Улсын хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу 28 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.

2.8. Ажлын хэсэг зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж, байгууллагын Инженер-техникийн ажилтан, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник хангамжтай шаардлагатай тохиолдолд газар дээр нь танилцаж, ирүүлсэн материалыг хянан үзэж тусгай зөвшөөрлийг олгох дүгнэлт гаргана.

2.9. Тусгай зөвшөөрлийг энэхүү журмын 2.3, 2.4, 2.5 болон хавсралтад заасан нөхцөл, шаардлагыг хангасан Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад энэ журмын хавсралтад заасан ажлын төрлөөр 3 жил хүртэл хугацаагаар олгоно.

2.10. Шаардлага хангахгүй тохиолдолд Ажлын хэсэг тусгай зөвшөөрөл олгох болон сунгахаас татгалзах эрхтэй.

ГУРАВ. Тусгай зөвшөөрөл авах аж ахуйн нэгжид тавигдах өрөнхий шаардлага

3.1. Тусгай зөвшөөрөл авах аж ахуйн нэгж нь эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамаарч журмын хавсралтад заасан инженер техникийн ажилтан болон холбогдох мэргэжилтэй ажиллагсадтай байна.

3.2. Шаардлагатай инженер-техникийн ажилтнуудын мэргэжлийн дипломын хуулбарыг хавсаргана. Шаардлагатай тохиолдолд эх хувийг шалгана.

3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага нь чадавхийн мэдээлэл, инженер техникийн ажилтны шилжилт хөдөлгөөнийг тухай бүрт нь Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэдээллийн санд бүртгүүлнэ.

3.4. Тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь тухайн ажлыг гүйцэтгэхэд технологийн бурдэл, тоо хэмжээ, ашиглалтын шаардлага хангасан байхын зэрэгцээ нийт тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийн 60-аас доошгүй хувь нь тусгай зөвшөөрөл хүсч байгаа аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй өөрийн өмчлөлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл байна.

3.5. Зарим тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг түрээсээр ажиллуулж болох ба энэ тохиолдолд түрээслүүлэгч байгууллагатай түрээсийн гэрээ байгуулсан байна. Тоног төхөөрөмжийн техник ашиглалтын байдлыг харуулсан техникийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар батлуулан түрээсийн гэрээнд хавсаргана.

3.6. Тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж нь авто замын салбарт үйл ажиллагаа явуулахад мөрдөх Үндэсний стандарт, норм норматив болон бусад техникийн баримт бичгийн бүрдэлтэй байх ба баримт бичиг худалдан авсан баримтыг хавсаргана.

3.7. Тусгай зөвшөөрөл хүссэн баримт бичгийн үнэн зөв болохыг баталгаажуулан аж ахуйн нэгж, байгууллагын захирал /дарга/ гарын үсэг зурж, тэмдэг дарсан байна.

**ДӨРӨВ. Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх,
хүчингүй болгох, сунгах**

4.1. Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасныг үндэслэн тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага түүнийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

4.2. Дээр дурьдсан нөхцөл байдал үүссэнд нотолсон эрх бүхий байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг ажлын хэсэг Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулан шийдвэрлүүлнэ.

4.3. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанад З хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

4.4. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нөхцөл, байдал арилсан тухай гомдол гаргасан захиалагч болон мэргэжлийн хяналтын байгууллагын саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийг сэргээж болно.

4.5. Тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно.

4.5.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

4.5.2. хуулийн этгээд татан буугдсан;

4.5.3. тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон ;

4.5.4. тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

4.5.5. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

4.6. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар шийдвэр гарснаас хойш З хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанад бичгээр мэдэгдэнэ.

4.7. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон мөн тусгай зөвшөөрлөө гээгдүүлсэн аж ахуйн нэгж байгууллага шаардлага хангасан нөхцөлд зөвшөөрөл авах хүсэлтээ дахин гаргаж болно. Тусгай зөвшөөрлийг үрэгдүүлсэн аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн олгохыг хүссэн өргөдөл, тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг үндэслэн гэрчилгээг нөхжөн олгоно.

4.8. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас ажлын 30 өдрийн өмнө тусгай зөвшөөрлийг эзэмшигч нь уг зөвшөөрлийг сунгуулах хүсэлтээ Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хургүүлнэ.

4.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг үндэслэн ажлын 28 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах эсэх талаар энэхүү журмын 2.1-т заасан ажлын хэсэг дүгнэлт гаргана.

4.10. Ажлын хэсэг тусгай зөвшөөрлийг сунгах эсэх тухай гаргасан дүгнэлтээ Авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж шийдвэрлүүлнэ. Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг анх олгосон хугацаанаас доошгүй хугацаагаар сунгах ба голлох бичиг баримтыг дахин бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

- 4.10.1. Хүсэлт гаргагчийн мэдээлэл
- 4.10.2. Холбогдох ажлын төрлийг хүссэн өргөдөл
- 4.10.3. Инженер техникийн ажилтны мэдээлэл
- 4.10.4. Урьд жилүүдэд хийж гүйцэтгэсэн ажлууд
- 4.10.5. Механизм тоног төхөөрөмжийн жагсаалт мэдээлэл

ТАВ. Зөвшөөрөл олгоход авах хураамж, хариуцлага

5.1. Тусгай зөвшөөрөл олгоход Монгол Улсын Тэмдэгтийн хураамжийн хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтлан тэмдэгтийн хураамж авч улсын төсөвт шилжүүлнэ.

5.2. Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж нь тэмдэгтийн хураамжийг төлнө.

5.3. Тусгай зөвшөөрөл олгох, тудгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг Монгол Улсын холбогдох хуулийн дагуу шийдвэрлэнэ.

-----оо-----

Тесел

журмын хавсралт

НЭГ. Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах, техник, технологийн хянант тавих зөвлөх үйлчилгээ Узүүлэх ажлын хүрээнд Нийтийн нэхцэл шаардлагыг хангахаас гадна дараах шаардлагыг хангасан байна.

10

		<p>Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багажнуудыг чадварлаг эзэмшидэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.</p>
	Геодезийн инженер-1	<p>Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мен замын зураг төслийн ажилд төсөвчнөөр ажилласан байх /энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./</p>
1.2. Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил		
1.2.1. Хурдны болон I ангиллын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах /замын байгууламжид 18 ум-ээс ихтийг түүр, түүрэн гарц, усны хоолий, авто замын хөдөлгөөнд зориулсан газар долгуурх гарц, хонгил, ус замууллах шуудуу, замын хөдөлгөөний		
	Авто замын инженер-3	<p>Аль нэг авто замын инженер нь тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн туршлагатай бөгөөд түүний 10 жил нь тухайн чиглэлийн гүйцэтгэсэн байх, Зөвлөх зэрэгтэй байх шаардлагатай.</p>
	Гүрийн инженер-1	<p>Тухайн мэргэжлээрээ 15-аас доошгүй жилийн туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх зэрэгтэй шаардлагатай</p>

<p>аюулгүй байдлыг хангах зорилтуултай авто замын зуравс газарт байгаа бусад байгууламжнууд хамаарна/</p> <p>Геодезийн инженер-1</p> <p>Хөдөлгөөн зохион байгуулалтын инженер-1</p>	<p>Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж тоог төхөөрөмжийг чадварлаг эзэмшидэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.</p> <p>Тухайн мэргэжлээрээ 5-аас багагүй жил ажилласан ажлын туршлагатай байх</p>	<p>Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мен замын зураг төслийн ажилд Мэргэшсэн төсөвччинөөр ажилласан байх /энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./</p> <p>Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 1 жилд нь замын хайгуул, зураг төсөл дээр ажилласан байх</p>	<p>Зургийн техникич - 3</p> <p>1.2.2. II болгон түүнээс доош ангилалын авто замын байгууламжийн зураг төсөл боловсруулах /замын байгууламжид 30 ум-ээс ихгүй гүр, гүрэн гарц, хиймэл</p>
			<p>Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Зөвлөх зэрэгтэй байх,</p> <p>Компьютер, тоног төхөөрөмж, Программ хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм Унэлгээ, Төсөв зохиц программын хангамжтай байх</p>

Байгууламж, авто замын хөдөлгөөнд газар доогуурх хонил, шуудуу, хөдөлгөөний байдлыг зориулалттай замын байгаа байгууламжууд замаарна/	Гүрүийн инженер-1 Геодезийн инженер-1 Төсөвчин-1 Зургийн техникч - 2	Тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй түүний 5 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, мэргэшсэн зэрэгтэй байх	Тухайн мэргэжлээрээ 5 жилүүн ажлын туршлагатай үнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшидэг байх. GPS болон топографын судалгаа, холбоотой түүнтэй хангамжийг Мэргэжлийн түвшинда ашиглаж чаддаг байх.	Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилүүн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд Мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх /энэ чиглэлээр 5-аас доошгүй жилүүн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./	Энэ чиглэлээр 3 жилүүн ажлын замын хайлцалт, зураг төсөл дээр ажилласан байх	Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй жилүүн ажлын туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, зөвлөх зэрэгтэй байх.
1.2.3. Хотын авто зам, замын байгууламжийн зураг боловсруулах /замын 30 ум-ээс ихгүй гүр,	Авто замын инженер-2	Нийвэлир, теодолит, гэх мэд геодезийн хэмжилтийн багаж, хайтуулын ажлын машин, Стандарт норм дурэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиц программын хангамжтай байх				

<p>Гүрэн гарц, усны замын хөдөлгөөнд зориулсан газар доогуурх гарч, хонгил, ус залпуулах замын шуудуу, хөдөлгөөний аюулгүй хангах зориулалттай замын зурсас газарт бусад байгаа байгууламжийн байгуулалтад хамаарна./</p>	<p>Гүрийн инженер-2 Геодезийн инженер-1 Хөдөлгөөн зохион байгуулалтын инженер-1</p>	<p>Аль нэг инженер нь тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 5 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх, Мэргэжлийн зэрэгтэй байх шаардлагатай Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үүнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн бараж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшидэг байх. GPS болон топографын судалгаа, холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх. Тухайн мэргэжлээрээ 3-аас багагүй жил ажилласан ажлын туршлагатай байх.</p> <p>Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд Мэргэжлийн төсөвчнеөр ажилласан байх /энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./ Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үүнээс 1 жилд нь зураг төслийн ажилд ажилласан байх</p> <p>Зургийн техники - 3</p>
---	---	---

1.3. Нисэх буудлын хөөрч буух зурвасын зураг төсөл боловсруулах ажил

<p>1.3.1. Нисэх буудлын хөөрч буух зураг төсөл боловсруулах</p> <p>Аэродромын инженер-1</p> <p>Авто замын инженер-1</p> <p>Геодезийн инженер-1</p> <p>Зургийн техники - 2</p>	<p>Тухайн доошгүй туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх,</p> <p>Тухайн мэргэжлээрээ 10-аас доошгүй туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх,</p> <p>Тухайн мэргэжлээрээ 8-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 6 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх,</p> <p>Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажил гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилд Мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх /энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./</p> <p>Энэ чиглэлээр 3 замын туршлагатай, үнээс 2 жилд нь хайлцалтад, зураг төсөл дээр ажилласан байх.</p>	<p>10-аас доошгүй туршлагатай бөгөөд түүний 8 жил нь тухайн чиглэлийн ажлын эхийн стандарт норм дүрэм, төсвийн норм унэлгээ, төсөв зохиох программ хангамжтай байх</p> <p>Компьютер, тоног төхөөрөмж, хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайтуулын эжлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм унэлгээ, төсөв зохиох программ хангамжтай байх</p> <p>Компьютер, тоног төхөөрөмж, хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайтуулын эжлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм унэлгээ, төсөв зохиох программ хангамжтай байх</p> <p>Компьютер, тоног төхөөрөмж, хангамж, Нивелир, теодолит гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайтуулын эжлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм унэлгээ, төсөв зохиох программ хангамжтай байх</p>
<p>1.4. Гүр, түннелийн зураг төсөл боловсруулах</p> <p>1.4.1. Гүр, түннелийн зураг төсөл боловсруулах</p> <p>Гүрнийн инженер-2</p>		

Зорчигчийн хөдөлгөөнд газар зориулсан доогуурх гарын бүх мерлийн түүнчел/	Авто замын инженер - 1	Тухайн мэргэжлээрээ 6-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 5 жил нь тухайн чиглэлийн зэрэгтэй байх шаардлагатай.
Геодезийн инженер-1		Тухайн мэргэжлээрээ 5 жилийн ажлын туршлагатай үнээс 3 жилд нь замын зураг төсөл дээр геодезийн инженерээр ажилласан байх шаардлагатай. Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг чадварлаг эзэмшидэг байх. GPS болон топографын судалгаа, түүнтэй холбоотой программ хангамжийг мэргэжлийн түвшинд ашиглаж чаддаг байх.
Төсөвчин-1		Тухайн мэргэжлээрээ 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай бөгөөд түүний 3 жил нь тухайн чиглэлийн ажилт гүйцэтгэсэн байх. Мөн замын зураг төслийн ажилдаа Мэргэшсэн төсөвчнөөр ажилласан байх /энэ чиглэлээр 5-аас доошгүй жилийн ажлын туршлагатай авто замын инженер байж болно./
Зургийн техникч - 3		Энэ чиглэлээр 3 жилийн ажлын туршлагатай, үнээс 2 жилд нь замын зураг төслийн ажилд ажилласан байх,

1.5. Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх

1.5.1. Техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх	Төслийн захирал /Зөвлөхийн захирал/	Зам барилгын ажилд 15 жил, үнээс 10-аас доошгүй жил зураг төслийн болон хянaltaар ажилласан Зөвлөх инженер,	Компьютер, хангамж, Нивелир, хэмжилтийн багаж, ажлын	Тоног хөхөрөмж, гэх мэд геодезийн машин, Стандарт	Программ
--	--	---	--	---	----------

	Хянантын батийн ахлагч	Зам барилгын чиглэлээр 10 жил, норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиц болон хянантанд ажилласан, зам, гурийн инженерийн мэргэжилтэй Мэргэшсэн инженер байх	норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиц программ хангамжтай байх
	Замны инженер-2	Зам барилгын чиглэлээр 5 жил, Унээс 3-аас доошгүй жил, хянантанд ажилласан, замын инженерийн мэргэжилтэй байх. Аль нэг инженер нь Мэргэшсэн зэрэгтэй байх.	Зам барилгын чиглэлээр 5 жил, Унээс 3-аас доошгүй жил, хянантанд ажилласан, гурийн инженерийн мэргэжилтэй байх
	Гурийн инженер-1	Тухайн чиглэлээр 5 жил, Унээс 3-аас доошгүй жил хянантгаар ажилласан, хянантын ажлын туршлагатай, зам, гурийн инженерийн мэргэжилтэй байх эсвэл дээрхи шаардлагыг хангасан барилгын материалиын инженер байж болно.	Тухайн чиглэлээр 5 жил, Унээс 3-аас доошгүй жил хянантгаар ажилласан, хянантын ажлын туршлагатай, зам, гурийн инженерийн мэргэжилтэй, Мэргэшсэн төсөвчийн байх
Материалын инженер-2	Тоо хэмжээний инженер-1	Тухайн чиглэлээр 5 жил, Унээс 3-аас доошгүй жил хянантанд ажилласан, хянантын туршлагатай, зам, гурийн инженерийн мэргэжилтэй байж болно.	
Хэмжилтийн инженер-1			

		Тухайн чиглэлээр 2-оос доошгүй ба жил ажилласан, хэмжилт түршлагатай материалын ажлын зам, гурийн болон байх бөгөөд зам, гурийн чиглэлийн техникийн геодезийн чиглэлийн мэргэжилтэй байх.
		

ХОЁР. Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах ажлын хүрээнд

Нийтлэг нөхцөл шаардлагыг хангахаас гадна дараах шаардлагыг хангасан байна.

Суурь нөхцөл, шаардлага:

Ажилбар	Шаардлагатай инженер-техникийн ажилтан	Шалтуур үзүүлэлт	Шаардлагатай машин, механизм, тоног төхөөрөмж				
2.1. Авто замын барилга							
2.1.1. Хатуу хүчинлэг зам барих /цементбетон, асфальтбетон, хөнгөвчилсөн хүчилт 12 ум хүртэлх замын ус залуулах /	<table border="1"> <tr> <td>Авто замын инженер-3 Гүүр, хиймэл байгууламжийн инженер -1</td><td>Аль нэг инженер нь мэргэшсэн зэрэгтэй байна. Ажлын туршлагатай байх</td><td>Экскаватор-2 Бульдозер-1 Автогрейдер-2 Ачигч-3 Доргиурт индуу-1 Хийн дугуйт индуу-1 Асфальтын индуу-1 Автолударнатор Өөрөө буулгагч-1 Усны машин-2 Асфальт дэвсэгч-1 Авто кран-1 Шигшүүртэй чулуу буулгур-1 Асфальтобетон завод-1 Лаборатори /иж бүрэн/-1 Геодезийн иж бүрдэл-1 Хээрийн лаборатори-1</td><td>Экскаватор-2 Бульдозер-1 Автогрейдер-1 Ачигч-1 Доргиурт индуу-1 Хийн дугуйт индуу-1 Индуу-1 Өөрөө буулгагч-2</td></tr> </table>	Авто замын инженер-3 Гүүр, хиймэл байгууламжийн инженер -1	Аль нэг инженер нь мэргэшсэн зэрэгтэй байна. Ажлын туршлагатай байх	Экскаватор-2 Бульдозер-1 Автогрейдер-2 Ачигч-3 Доргиурт индуу-1 Хийн дугуйт индуу-1 Асфальтын индуу-1 Автолударнатор Өөрөө буулгагч-1 Усны машин-2 Асфальт дэвсэгч-1 Авто кран-1 Шигшүүртэй чулуу буулгур-1 Асфальтобетон завод-1 Лаборатори /иж бүрэн/-1 Геодезийн иж бүрдэл-1 Хээрийн лаборатори-1	Экскаватор-2 Бульдозер-1 Автогрейдер-1 Ачигч-1 Доргиурт индуу-1 Хийн дугуйт индуу-1 Индуу-1 Өөрөө буулгагч-2	Материалын инженер-1	Ажлын туршлагатай байх
Авто замын инженер-3 Гүүр, хиймэл байгууламжийн инженер -1	Аль нэг инженер нь мэргэшсэн зэрэгтэй байна. Ажлын туршлагатай байх	Экскаватор-2 Бульдозер-1 Автогрейдер-2 Ачигч-3 Доргиурт индуу-1 Хийн дугуйт индуу-1 Асфальтын индуу-1 Автолударнатор Өөрөө буулгагч-1 Усны машин-2 Асфальт дэвсэгч-1 Авто кран-1 Шигшүүртэй чулуу буулгур-1 Асфальтобетон завод-1 Лаборатори /иж бүрэн/-1 Геодезийн иж бүрдэл-1 Хээрийн лаборатори-1	Экскаватор-2 Бульдозер-1 Автогрейдер-1 Ачигч-1 Доргиурт индуу-1 Хийн дугуйт индуу-1 Индуу-1 Өөрөө буулгагч-2				
2.1.2. Хүчинлэг зам барих	<table border="1"> <tr> <td>Авто замын инженер-2 Геодезийн инженер-1</td><td>Аль нэг инженер нь мэргэшсэн зэрэгтэй байна. Ажлын туршлагатай байх</td><td>Экскаватор-1 Бульдозер-1 Автогрейдер-1 Ачигч-1 Доргиурт индуу-1 Хийн дугуйт индуу-1 Индуу-1 Өөрөө буулгагч-2</td></tr> </table>	Авто замын инженер-2 Геодезийн инженер-1	Аль нэг инженер нь мэргэшсэн зэрэгтэй байна. Ажлын туршлагатай байх	Экскаватор-1 Бульдозер-1 Автогрейдер-1 Ачигч-1 Доргиурт индуу-1 Хийн дугуйт индуу-1 Индуу-1 Өөрөө буулгагч-2			
Авто замын инженер-2 Геодезийн инженер-1	Аль нэг инженер нь мэргэшсэн зэрэгтэй байна. Ажлын туршлагатай байх	Экскаватор-1 Бульдозер-1 Автогрейдер-1 Ачигч-1 Доргиурт индуу-1 Хийн дугуйт индуу-1 Индуу-1 Өөрөө буулгагч-2					

	Материалын инженер-1	Ажлын туршлагатай байх	Усны машин-1 Шилгшүүртэй чупуу булгруур-1 Лабораторий-1 Геодезийн иж бурдэл-1
2.2. Авто замын байгууламж			
2.2.1. Бүх төрлийн гүүр, гүүрэн гарам /12 ум-ээс дээшхи бүх төрлийн ус зайлзуулах хиймэл байгууламжууд/	Авто замын инженер-1 Геодезийн инженер-1	Ажлын туршлагатай байх Ажлын туршлагатай байх	Экскаватор-1 Бульдозер-1 Автогрейдер-1 Ачилг-2 Доргилүрт индуу-1 Хийн дугуйт индуу-1 Өөрөө буулгатч-1 Усны машин-1 Автофран-2 Лабораторий-1 Геодезийн иж бурдэл-1
	Материалын инженер-1	Ажлын туршлагатай байх	Экскаватор-1 Бульдозер-1 Автогрейдер-1 Ачилг-1 Доргилүрт индуу-1 Хийн дугуйт индуу-1 Өөрөө буулгатч-1 Автофран-1 Лабораторий-1 Геодезийн иж бурдэл-1
2.2.2. Туннель,газар доогуур нүхэн гарам барих,засах	Материалын инженер-2	Ажлын туршлагатай байх	

2.3. Зам барилга, засварын материал, хийцийн үйлдвэрлэл

<table border="1"> <tr> <td>Авто замын инженер-1</td><td>Экскаватор-1 Бульдозер-1 Автогрейдер-1 Ачигч-2 Өөрөө буулгач-4 Усны машин-1 Шилтшүүртэй чулуу буулгур-1 Асфальтобетон завод-1 Бетон зурагч-1</td></tr> <tr> <td>Гүүрийн инженер-1</td><td></td></tr> </table> <p>2.3.1. Зам барилга, засварын материал, хийцийн үйлдвэрлэл</p>		Авто замын инженер-1	Экскаватор-1 Бульдозер-1 Автогрейдер-1 Ачигч-2 Өөрөө буулгач-4 Усны машин-1 Шилтшүүртэй чулуу буулгур-1 Асфальтобетон завод-1 Бетон зурагч-1	Гүүрийн инженер-1	
Авто замын инженер-1	Экскаватор-1 Бульдозер-1 Автогрейдер-1 Ачигч-2 Өөрөө буулгач-4 Усны машин-1 Шилтшүүртэй чулуу буулгур-1 Асфальтобетон завод-1 Бетон зурагч-1				
Гүүрийн инженер-1					
Mатериалын инженер-2	Ажлын туршлагатай байх				

2.4. Авто замын засвар, арчлалтын ажил

<table border="1"> <tr> <td>Авто замын инженер-1</td><td>Автогрейдер-1 Ачигч-1 Индүү-1 Экскаватор-1</td></tr> <tr> <td>Геодезийн инженер-1</td><td>Ажлын туршлагатай байх</td></tr> <tr> <td>Материалын инженер-1</td><td></td></tr> </table> <p>2.4.1. Бүх төрлийн замын засварын ажил</p>	Авто замын инженер-1	Автогрейдер-1 Ачигч-1 Индүү-1 Экскаватор-1	Геодезийн инженер-1	Ажлын туршлагатай байх	Материалын инженер-1	
Авто замын инженер-1	Автогрейдер-1 Ачигч-1 Индүү-1 Экскаватор-1					
Геодезийн инженер-1	Ажлын туршлагатай байх					
Материалын инженер-1						
<table border="1"> <tr> <td>Авто замын инженер-1</td> <td>Автокран-1 Бетон зурагч-1</td> </tr> <tr> <td>Гүүрийн инженер-1</td> <td>Ажлын туршлагатай байх</td> </tr> <tr> <td>Материалын инженер-1</td> <td></td> </tr> </table> <p>2.4.2. Бүх төрлийн Гүүрийн засварын ажил</p>	Авто замын инженер-1	Автокран-1 Бетон зурагч-1	Гүүрийн инженер-1	Ажлын туршлагатай байх	Материалын инженер-1	
Авто замын инженер-1	Автокран-1 Бетон зурагч-1					
Гүүрийн инженер-1	Ажлын туршлагатай байх					
Материалын инженер-1						
<table border="1"> <tr> <td>Авто замын инженер-1</td> <td>Автогрейдер-1 Ачигч-1</td> </tr> <tr> <td>Авто замын инженер-1</td> <td>Ажлын туршлагатай байх</td> </tr> </table> <p>2.4.3. Зам, талбайн тохижилтын ажил</p>	Авто замын инженер-1	Автогрейдер-1 Ачигч-1	Авто замын инженер-1	Ажлын туршлагатай байх		
Авто замын инженер-1	Автогрейдер-1 Ачигч-1					
Авто замын инженер-1	Ажлын туршлагатай байх					

хийх, засварлах	Материалын инженер-1		ИНДҮҮ-1 Эксколоватор-1
2.4.4. Замын тоноглол, тэмдэг, тэмдэглээний ажил	Авто замын инженер-1	Ажлын туршлагатай байх	Замын тэмдэг үйлдвэрлэх тоног төхөөрөмж, тэмдэглээний машин
2.4.5. Бүх төрлийн зам, замын байгууламжийн арчилалтын ажил	Авто замын инженер-1	Ажлын туршлагатай байх	Автогрейдер-1 Ачиг-1 Бага оврын ИНДҮҮ-1